



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

XXVIII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 84 хувийн ирцтэй хуралдуулав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд*

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц бүрдүүлэлтийн талаар

*Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын дарга Б.Цэцэгсайхан,*

3. Хилийн боомтуудын нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

*Хилийн боомтын Онцгой бүрэн эрхт захиргааны
орлогч дарга П.Билгүүн,*

4. Шүлхий, арьс товруутах, мялзан зэрэг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан*

5. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын мутацилагдсан хувилбарын тархалтаас сэргийлэх, халдварын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор хийж буй дархлаа сэргээх нэмэлт тунд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл иргэдийг идэвхитэй хамруулахад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх, үр дүнг тухай бүр Улсын онцгой комисст танилцуулах;

1.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгийн үр дүн, зайлшгүй хамрагдах хэрэгцээ шаардлага, ач холбогдлын талаарх мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд тогтмол хүргэж ажиллах;

1.3. Томуу, томуу төст өвчин, коронавируст халдвар /Ковид-19/-ын шинж тэмдэг, өвчлөлийн ялгаа, халдварын дараах нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээний талаар эрдэмтэн судлаач, эмч, мэргэжилтнүүдийн зөвөлгөө, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд тогтмол өгөх;

1.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвараас сэргийлэх дэглэмийг мөрдүүлж, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгуулсан "Хариуцлагын гэрээ"-ний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1.5. Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс нээсэн олон нийтийн арга хэмжээг заал, танхимын 50 хувийн дүүргэлттэй, үзэгчтэй зохион байгуулах тохиолдолд үзэгч, оролцогчдыг дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсан эсэхийг шалгах, хамрагдаагүй бол түргэвчилсэн шинжилгээг тухайн орчинд авах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулагч тал хариуцах талаар шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллах;

Хоёр. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга Б.Цэцэгсайхан нарт:

2.1. Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэлтийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, тэдгээрийг дотоодод үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эдийн 3 сарын нөөцийг 2022 оны 1 дүгээр сарын 01-ний дотор бүрдүүлж, тасалдал, хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавих;

2.2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эмчилгээнд шинээр нэвтэрч буй эм, тарианы талаар тогтмол судалгаа хийж, шаардлагатай тохиолдолд худалдан авах ажлыг зохион байгуулах;

2.3. Коронавируст халдвар (Ковид-19)-аар өвчилсний дараах нөхөн сэргээх эмчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд:

3.1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын нэмэлт тунд оюутнуудын хамрагдах идэвхи сул байгааг онцгойлон анхаарч их, дээд сургуулиудын хүрээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх тодорхой ажил зохион байгуулж ажиллах;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Б.Ганзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Хөдөө, аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл, малчдын отор нүүдэлд холбогдох асуудалд онцгойлон анхаарч, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

4.2. Зарим аймгийн нутагт олон улсын худалдааны хорио цээрт мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарч байгаатай холбогдуулан “Мал, амьтны гоц халдварт өвчний талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

4.3. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, дэгдэлтээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг нарийвчлан гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах /тодорхой судалгаа, дүгнэлтэд үндэслэн ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэн хариуцах, ямар үр дүнд хүрэх гэх мэт/;

4.4. Мал эмнэлгийн ерөнхий газрын малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, өвчний тархалтыг хязгаарлах, голомтыг цомхотгох нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.5. Мал, амьтны гоц халдварт өвчний тохиолдол, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар иргэд, малчдад тогтмол мэдээ, мэдээлэл хүргэх, аймгууд дахь мал эмнэлгийн газруудын ажлын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

Тав. Гадаад харилцааны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар, Хилийн боомтын Онцгой бүрэн эрхт захиргааны дарга, хошууч генерал Ш.Лхачинжав нарт:

5.1. Хилээр нэвтрүүлэх бараа материал, ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ талаар БНХАУ-ын талтай дипломат шугамаар яриа хэлэлцээ хийх;

5.2. Манай талын санаачилгаар хаасан, зарим хязгаарлалт тогтоосон боомтуудыг хэвийн ажиллуулах, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс болон бусад бараа бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх зорилгоор хилийн боомтуудыг бүрэн хэмжээнд ажиллуулах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга, Б.Бат-Эрдэнэд:

6.1. Хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний тасалдал, хомсдол гарч байгаатай холбогдуулан зохиомол үнийн хөөрөгдөл үүсэхээс урьчилан сэргийлж ажиллах;

Долоо. Улсын онцгой комиссын гишүүн, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт:

7.1. Сайжруулсан шахмал түлшний хомсдол, тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай нөөц бүрдүүлэх, түгээлтийн цэгийг нэмэгдүүлэх талаар шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Найм. Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүүд:

8.1. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Тусгаарлан эмчлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам”, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Хот болон орон нутаг хооронд иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ыг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болгох;

Ес. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт

9.1. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам”, “Тусгаарлан эмчлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болгож байгаатай холбогдуулан уг журмуудыг цаг үеийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан шинэчлэн боловсруулж батлуулах;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ